



Олон Улсын
Улаанбаатарын Их Сургууль
국제울란바타르대학교



한국학중앙연구원
THE ACADEMY OF KOREAN STUDIES

2023

제3차 한국학 세미나

주제: 몽골 한국어 교수법 및
교재 현황

일시 : 2023.04.12(수) 16시

장소 : 국제울란바타르대학교 본관 A403호

IUU KOREAN
STUDIES CENTER

제 3 차 한국학 세미나

**주제: 몽골의 한국어 교수법 및
교재 현황**

일시 : 2023.04.12(수) 16 시

장소 : 국제울란바타르대학교 본관 A403 호

주최 : 국제울란바타르대학교 한국학연구소, 대학원(한국학과)

주관 : 국제울란바타르대학교 해외한국학정책대학육성사업단

강사 소개



MEND Nergui 교수

연세대학교 한국학협동과정 한국학 박사

소속: 몽골국립과학기술대학교, 외국어대학 한국어 교수

주 연구분야: 말뭉치, 전공 어휘, 문학번역



ARIUNBAATAR Bayagaa 교수

연세대학교 교육학 박사

소속: 국제울란바타르대학교 한국어교육학과 학과장

주 연구분야: 교육과정학, 외국어 교수법, 한국어 교수법
개발, 교원 전문성 개발

이 자료집은 2022년 대한민국 교육부와 한국학중앙연구원(한국학진흥사업단)을
통해 해외한국학중핵대학육성사업의 자원을 받아 수행된 연구임

(AKS-2022-OLU-2250006)



국제울란바타르대학교, 한국학 연구소
한국학진흥사업단 '해외한국학 중핵대학 육성사업'



제3차 한국학 세미나

몽골 한국어 교수법 및 교재 현황

일시

2023.04.12(수)
16:00-17:30

장소

국제울란바타르대학교 A동, 403
온라인 줌 병행

시간	내용
15:30-15:55	등록, 다과
16:00-16:05	사업단장 인사: 강선화 PhD(국제울란바타르대학교)
16:05-16:35	강사: 엔. 멘드 교수(몽골 과학기술대) 주제: 몽골 내 대학에서의 한국학 교재 현황 및 문제점
16:35-16:45	질의 응답
16:45-17:15	강사: 베. 아리웅바타르 교수(국제울란바타르대학교) 주제: 몽골인을 위한 한국어 교수법 개발 - SODAR의 예를 중심으로
17:15-17:25	질의 응답
17:25-17:30	기념 촬영 및 공지

ZOOM ID: 829 5581 3299
PW: 12345

등록
QR code



✉ koreanstudies@ulaanbaatar.edu.mn

🌐 www.ksc.iuu.mn

☎ 9100-9474, 8873-7720

📘 Korean Studies Center



Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Солонгос судлалын хүрээлэн
Их сургуулийг түшиглэн солонгос судлалыг хилийн чанадад хөгжүүлэх төсөл



СОЛОНГОС СУДЛАЛЫН ГУРАВДУГААР СЕМИНАР

СОЛОНГОС ХЭЛНИЙ ЗААХ АРГА ЗҮЙ ба СУРАХ БИЧИГ

ХЭЗЭЭ

2023.04.12(Лхагва)
16:00-17:30 цаг

ХААНА

ОУУБИС-ийн А байр, 403
Онлайн зүүм хамт

Цаг	Хөтөлбөр
15:30-15:55	Бүртгэл, coffee break
16:00-16:05	Нээлтийн үг Төслийн удирдагч: КАН СОНЬ ХУА(ОУУБИС, доктор)
16:05-16:35	Лектор: Н. Мэнд (ШУТИС, доктор) Сэдэв: Монголын их дээд сургуульд ашиглаж буй солонгос орон судлалын сурах бичиг, тулгамдаж буй асуудал
16:35-16:45	Асуулт, хариулт
16:45-17:15	Лектор: Б. Ариунбаатар(ОУУБИС, доктор) Сэдэв : Монгол хүнд зориулсан солонгос хэлний заах арга – Содар аргын жишээгээр
17:15-17:25	Асуулт, хариулт
17:25-17:30	Дурсгалын зураг, зарлал

Онлайн(ZOOM)

ID: 875 5389 8058

PW: 12345

Бүртгэлийн QR code



✉ koreanstudies@ulaanbaatar.edu.mn

☎ 9100-9474, 8873-7720

🌐 www.ksc.iuu.mn

📘 Korean Studies Center

Монголын их дээд сургуульд ашиглаж буй солонгос судлалын сурах бичиг, тулгамдаж буй асуудал

Н.Мэнд (Ph.D., дэд проф.)
ШУТИС ГХС, mend@must.edu.mn

Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа 1990 оны “Дипломат харилцаа тогтоох тухай Протокол”, 1991, 1999, 2006, 2011 оны дээд түвшний айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улс, БНСУ-ын Хамтарсан мэдэгдэл”, 1999 оны “XXI зууны харилцан бие биеэ нөхсөн хамтын ажиллагаа”, 2006 оны “Сайн хөршийн, найрамдалт хамтын ажиллагааны түншлэл”, 2011 оны “Иж бүрэн түншлэл”-ийн зарчимд тулгуурлан тууштай хөгжиж ирсэн бөгөөд хоёр улс харилцаагаа “Стратегийн түншлэл”-ийн зарчим дээр тулгуурлан гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь Монгол, Солонгос төдийгүй бүс нутаг, олон улсын энх тайвныг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Энд мэргэжлийн өндөр мэдлэгтэй, солонгос хэлтэй, Солонгос орон судлаачид гол үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Өнөөдөр Монгол улсын их сургуульд “Гадаад хэл, орон судлал /Солонгос/”, Олон улсын Улаанбаатарын их сургуульд “Олон улс, орон судлал-Солонгос судлал” хөтөлбөрөөр Солонгос орон судлаачдыг бэлтгэн гаргаж байна. Энэхүү илтгэл нь Солонгос орон судлалын хөтөлбөрөөр зааж буй солонгос орон судлалын хичээлд¹ ашиглаж буй сурах бичгийн судалгаа хийж, тулгамдаж буй асуудлыг хөндөн гаргахыг зорилго болголоо.

Судлагдсан байдал

Монгол дахь их дээд сургуулиудын солонгос хэл, солонгос судлалын сургалтын өнөөгийн байдал, хэрэглэгдэж буй сурах бичгийн талаарх судалгаа 2000 оноос эхэлсэн бөгөөд Квон Сонхунь (2009) судалгаандаа “солонгос хэлний сурах бичиг зохиох ажлыг 1991-2000 он хүртэл солонгос мэргэжилтнүүд, 2001 оноос хойш монгол судлаачид голлон хийж байгаа бөгөөд солонгос хэлний ур чадвар тус бүрээр, хэлний ур чадварын цогц сурах бичиг болон бие даан сурах гарын авлага, солонгос-монгол, монгол-солонгос толь бичиг, уран зохиол, соёл, ёс заншил, угсаатны зүй, нийгэм-эдийн засгийн холбогдолтой сурах бичиг цөөхөн хэдий ч хэвлэгдсэн.” болохыг дурдсан. Д.Сайнбилэгт (2009) судалгаандаа солонгос хэлний сургалт явуулж буй байгууллага, хувь хүн тус бүр сурах бичиг зохиох ажилд анхаарал хандуулж хүчин чармайлт гаргаж ирсэн хэдий ч суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн сурах бичиг зохиогдоогүй байгааг онцлоод сурах бичгээс илүүтэй сурах бичгийн хүртээмж асуудалтай байгааг дурджээ. П.Адьяасүрэн (2008) Монголд солонгос хэлний сургалтад ашиглаж буй солонгос хэлний сурах бичигт судалгаа хийж, Улаанбаатар их сургуульд солонгос хэл судалж буй 2 болон 3 дугаар курсийн 69 оюутнаас ашиглагдаж буй сурах бичгийн талаарх судалгаа авч асуудалтай талыг тодорхойлон, шинэ сурах бичиг зохиох арга зүйг гаргасан. Д.Эрдэнэсүрэн (2020) Монголын их дээд сургуулиудад солонгос хэлний сурах бичиг зохион ашиглан буй байдал, тулгамдаж буй асуудлын талаар хөндсөн бол Уртнасан

¹ Энэ судалгаанд солонгос хэлтэй холбоотой хичээлийн сурах бичгийг багтаагаагүй болно.

(2005) Улаанбаатар их сургуульд хэрэглэгдэж буй солонгос хэлний сурах бичиг “Монгол хүнд зориулсан цогц сурах бичиг 1-6” болон Сэжун хэлний институтийн “Сэжун солонгос хэл” сурах бичгийг сонгон, сурах бичигт сонгон оруулсан соёлын бичвэрийн агуулгыг судалж, монголын нөхцөл байдалд тохирч байгаа эсэх, бүтэц болон агуулга суралцагчийн хэлний түвшний шаардлагад тохирсон эсэх, сурах бичигт гарч буй соёлын агуулга нь солонгос хэлээр харилцах ур чадвар болон соёлыг танин мэдэхэд тус болж, суралцагчид соёлын сэдэв тус бүрээр даалгавар гүйцэтгэх, төрөлх хэлтэйгээ харьцуулах замаар бүрэн ойлгож байгаа эсэх зэргийг судалж, судалгааны үр дүн дээр үндэслэн агуулгын бүтэц, чиглэл, сайжруулах арга замыг тодорхойлж гаргасан байна.

Солонгос судлалын хичээлд ашиглаж буй сурах бичиг

Сурах бичиг гэдэг нь тухайн боловсролын байгууллагын сургалтын бодлого, сургалтын хөтөлбөр зэрэгт суурилж ямар сургалт явуулахыг заадаг хэрэгслэл бөгөөд, сургахуй-сурахуйн үйл ажиллагаанд заавал байх ёстой хүчин зүйл юм. Хичнээн сайн сургалтын бодлого, хөтөлбөртэй байсан ч сурах бичиг хэмээх хэрэгслэлээр дамжуулан дэс дараалалтай, нарийн тодорхой явуулахгүй бол сургалтын процессоос ямар ч үр дүн гарахгүй нь тодорхой юм. Тиймээс сурах бичиг бол сургалтын зорилгыг хангахад чухал хэрэгсэл бөгөөд сурахуйн үр дүнд ихээхэн нөлөө үзүүлдэг. Эрдэмтэн Жу Ханнуг (2010) “гадаад хэлний сургалтын хамгийн гол 3 хүчин зүйл бол багш, суралцагч, сурах бичиг бөгөөд багш “түүнийг” заахад, суралцагч “түүнийг” сурахад, сурах бичиг “түүнийг” агуулсан системчилсэн хэрэгсэл болох бөгөөд сурах бичигт байгаа агуулга нь суралцагчид солонгос хэл, солонгосын нийгмийн талаарх үзэл баримтлалтай болгох үүрэг гүйцэтгэдэг.” хэмээжээ.

Өнөөдрийн байдлаар МУИС Гадаад хэл, орон судлал /Солонгос/, ОУУБИС Олон улс, орон судлал - Солонгос судлал мэргэжлээр солонгос орон судлаачдыг бэлтгэн гаргаж байна. МУИС хөтөлбөрийн зорилгоо “Орон судлал, орчуулгын онол, арга зүйг эзэмшсэн, хэл- түүх- соёл судлалын хүрээнд хөрвөх чадвартай, боловсон хүчинд тавих нийтлэг шаардлага хангасан солонгос хэлийг эзэмшсэн, солонгос судлалын мэргэжилтэн бэлтгэх” хэмээн тодорхойлсон бол ОУУБИС “БНСУ-тай гадаад харилцаа нэмэгдэх тусам оюутан залуусын хүсэл сонирхол, байнга өсөн нэмэгдэх Солонгос хэлний орчуулагч мэргэжлийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, Солонгос хэлний чадварлаг орчуулагч, Солонгос судлаач, Монгол Улсын нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулах мэргэжилтэн бэлтгэх” хэмээн тодорхойлжээ.

Солонгос орон судлалын хөтөлбөрийн зорилго

Сургууль	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрөөр олгох мэдлэг
МУИС	Гадаад хэл, орон судлал /Солонгос/ D023102	Орон судлал, орчуулгын онол, арга зүйг эзэмшсэн, хэл- түүх-соёл судлалын хүрээнд хөрвөх чадвартай, боловсон хүчинд тавих нийтлэг шаардлага хангасан солонгос хэлийг эзэмшсэн, солонгос судлалын мэргэжилтэн бэлтгэх	Солонгос судлалын онолын мэдлэг Солонгос хэл, хэл шинжлэлийн мэргэжлийн мэдлэг Солонгосын түүх, нийгэм улс төр, эдийн засаг, соёл урлаг, угсаатны зүйн мэдлэг Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, ерөнхий боловсролын бүх шатны сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад

			судлаач, багш, хэл бичгийн болон орчуулгын чиглэлээр ажиллах дадлага туршлага мэдлэг
ОУУБИС	Олон улс, орон судлал – Солонгос судлал D022203	БНСУ-тай гадаад харилцаа нэмэгдэх тусам оюутан залуусын хүсэл сонирхол, байнга өсөн нэмэгдэх Солонгос хэлний орчуулагч мэргэжлийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж, Солонгос хэлний чадварлаг орчуулагч, Солонгос судлаач, Монгол Улсын нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулах мэргэжилтэн бэлтгэх	Солонгос хэл, түүх соёл, улс төр, эдийн засаг, газарзүй, зан заншил, угсаатны зүй, нийгэм, аялал жуулчлал зэрэг Солонгос судлалтай холбоотой олон салбарын өндөр түвшний мэдлэгтэй, өөрийгөө хөгжүүлж, бие даан судалгаа хийх бүрэн чадвартай, Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын дундаас дээд шатанд тэнцсэн, мэргэжлийн орчуулга хийх чадвартай, улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах боловсон хүчин бэлтгэгдэнэ.

Монголын их дээд сургуулийн солонгос хэлний сургалт нь солонгос хэлний мэргэжилтэн бэлтгэх болон мэргэшүүлэхэд голлон анхаардаг тул анги дэвших тусам солонгос хэлний хичээлийн хувь багасаж солонгосын соёл, түүх, нийгэм, улс төр, эдийн засаг, уран зохиол гэх зэргээр солонгос хэлээр дамжуулан албан ажил хөтөлж явуулахад шаардлагатай ур чадварын болон солонгос судлалын чиглэлийн сургалт эзлэх хувь нэмэгддэг. Солонгос судлалын сургалт нь нэг, хоёрдугаар курстээ солонгос хэлний хичээлүүд судалж, солонгос хэл дээр солонгос судлалын материал уншиж, ашиглах хэлний суурийг тавьсны дараа хөтөлбөрт тусгасан солонгос судлал, солонгосын улс төр, эдийн засаг, нийгэм, гадаад харилцаа, эдийн засгийн газар зүй, түүх гэх зэргээр орон судлалын судалгаа хийх ур чадвар суулгах чиглэлийн сургалт эзэлдэг онцлогтой.

2000 оноос хойш монгол суралцагчдад зориулсан солонгосын улс төр, эдийн засаг, соёл, уран зохиол, солонгос зүйр цэцэн үг, аман болон бичгийн орчуулгын сурах бичиг зэрэг солонгос судлалтай холбоотой 30 гаруй төрлийн сурах бичиг зохиогдсон ба тодруулбал, солонгос хэлний 41, солонгос судлалын 12 сурах бичиг зохиогдон ашиглагдаж байна².

Мэргэжлийн солонгос орон судлаачид бэлддэг хоёр их сургуулийн хөтөлбөрт тусгагдсан хичээлүүдийг хүснэгтлэн харуулъя.

“Солонгос судлал” мэргэжлээр судалж буй хичээлүүд

№	МУИС	ОУУБИС
1	БНСУ-ын түүх 3кр /заавал/	Солонгосын түүх
2	БНСУ-ын улс төр, гадаад харилцаа /заавал/	Солонгосын улс төр
3	БНСУ-ын эдийн засгийн газар зүй /заавал/	Солонгосын бизнес, эдийн засаг

² Д.Эрдэнэсүрэн, Их дээд сургуулиудын солонгос хэлний сурах бичгийн асуудалд, Ази судлал Олон улсын эрдэм шинжилгээний зургаадугаар хурал, 2020

4	БНСУ-ын нийгэм соёл /заавал/	Солонгосын орчин үеийн нийгэм судлал
5	БНСУ-ын уран зохиолын удиртгал /заавал/	Солонгос орон судлал
6	Бүс нутаг судлал /Зүүн Хойд Ази судлал/ /сонгон/	Солонгос хүний сэтгэлгээ
7	Солонгосын сонгодог уран зохиол /сонгон/	Солонгосын соёл, заншил
8	БНСУ-ын орчин үеийн уран зохиол /сонгон/	Солонгосын орчин үеийн уран зохиол
9	Солонгосын угсаатны зүй /сонгон/	Солонгосын угсаатны зүй
10	Солонгосын соёлын орчуулга /сонгон/	Солонгос судлалын үндэс
11	Монгол Солонгосын харилцааны түүх /сонгон/ 3кр	Солонгос монгол судлал
12	БНСУ-ын соёлын гадаад бодлого 2кр /сонгон/	Солонгосын газар зүй
13	Солонгосын сонгодог утга зохиолын дээжис /сонгон/	Солонгосын эртний уран зохиол
14	Азийн соёл иргэншил ба орчин үеийн Ази /сонгон/	Солонгосын түүхийн сурвалж судлал
15	Солонгос хэлний албан бичгийн орчуулга /сонгон/	Солонгосын олон улсын харилцаа
16	Эртний солонгос хэл	Харьцуулсан судалгааны арга зүй

Хичээл тус бүрээр ашиглагдаж буй сурах бичиг, гарын авлагыг дэлгэрүүлэн харвал:

1. Солонгос орон судлал- мэргэжлийн орон судлаач бэлтгэдэг МУИС, ОУУБИС болон ХИС, ШУТИС, МҮИС зэрэг их дээд сургуулиуд заавал судлах хэлбэрээр хичээлийг судалж, тухайн хичээлийг зааж буй багшийн бэлдсэн гарын авлага болон багшийн лекцийн материал ашигладаг.
2. Солонгосын түүх - орон судлаач бэлтгэдэг МУИС, ОУУБИС-аас гадна Солонгос хэл судлаач, орчуулагч, багш бэлддэг МУБИС, ШУТИС, ХИС, МҮИС гэх зэрэг их дээд сургуулиуд сонгон хэлбэрээр хичээлийг судалж, Г.Эрдэнэчимэг зохиогчтой “Солонгосын түүх” /тэргүүн, дэд дэвтэр/ сурах бичгийг үндсэн сурах бичгээр, нэмэлт материалаар тухайн сургуулийн багш нарын зохиосон гарын авлага, интернэт материал ашиглаж байна.
3. Солонгосын улс төр – МУИС-д Солонгосын улс төр хичээлийг гадаад харилцаа талаас чухалчлан харж, ОУУБИС-д улс төрийн тогтолцоо, институц талаас нь судалдаг байна. Д.Сайнбилэгт зохиогчтой “БНСУ-ын улс төрийн тогтолцоо”, Амартайван “Солонгосын улс төр” сурах бичгийг үндсэн сурах бичгээр, нэмэлт материалаар цахим эх сурвалж болон багшийн лекцийн материал, Солонгосын улс төрийн тогтолцоог харуулсан уран сайхны кино хүртэл ашигладаг байна.
4. Солонгосын эдийн засаг – МУИС-д Солонгосын эдийн засгийг дан ганц эдийн засгийн хөгжил гэж судлахаас илүүтэй бүс нутагтаа нөлөөлж буй байдал, эдийн засгийн газар зүй талаас судалдаг онцлогтой байлаа. БНСУ-ын эдийн засгийн газар зүй хичээлийг заавал судлахаар хөтөлбөрт тусгасан бөгөөд Ким Гивонь, Ким Чонсү, Сун Жонхуань “Солонгосын аж үйлдвэрлэлийн тухай ойлголт”, Ким Дэри, Чон Инху “Орчин үеийн Солонгосын эдийн засаг” зэрэг сурах бичиг ашиглаж байна. ОУУБИС-д “Солонгосын бизнес, эдийн засаг” хичээл хөтөлбөрт тусгагдсан байх ба Солонгосын эдийн засгийг бизнесийн төрөл зүйл, эдийн засаг дахь бизнес эрхлэгчдийн үүрэг нөлөө талыг чухалчлан анхаарч судалдаг байна. Энэ хичээлд Г.Эрдэнэчимэг “БНСУ-ын эдийн засгийн тойм” үндсэн сурах бичгээр ашиглаж, Солонгосын дэлхийд данстай Самсунг, Хөндэй зэрэг компанийн

бизнесээ хэрхэн эхлүүлж, удирдаж ирсэн туршлагыг танилцуулсан номыг нэмэлт материалд оруулсан байна.

5. Солонгосын нийгэм – МУИС-д БНСУ-ын нийгэм, соёл нэртэй хичээлийг заавал судлахаар тусгаж Б.Норовням “Солонгосын нийгэм, соёл”, Ян Сынъгүг, Пак Сончан, Ань Гёнхуа “Гадаад хүнд зориулсан солонгосын соёлын 30 лекц” сурах бичгийг үндсэн сурах бичгээр, ОУУБИС-д Солонгосын орчин үеийн нийгэм судлал нэртэй хичээлийг сонгон судлахаар тусгаж Б.Норовням “Солонгосын нийгэм, соёл”, Ян Сынъгүг, Пак Сончан, Ань Гёнхуа “Гадаад хүнд зориулсан солонгосын соёлын 30 лекц” болон нэмэлт материалууд ашигладаг байна. Энэ хичээлийн сурах бичгээр хоёр сургууль ижил сурах бичиг ашиглаж байв.
6. Солонгосын соёл – МУИС-д “Солонгосын соёлын гадаад бодлого” хичээлийг сонгон судлахаар тусгаж үндсэн сурах бичгээр Ким Мүнхуань “Соёлын гадаад бодлого”, Юү Гэгонь “21-р зууны Солонгосын гадаад бодлого” сурах бичгийг, нэмэлт материалаар МУИС Ази судлалын тэнхимээс гаргасан “Солонгос судлал”, Монгол Солонгосын харилцааны 30 жилийн түүхэн замналын тухай материал зэргийг ашиглаж байв. ОУУБИС-д Солонгосын соёл, заншил Т.Буяннэмэх “Солонгосын соёл ба ёс заншил”, хилийн чанад дахь Солонгосчуудад зориулсан “Солонгосчуудын амьдрал I” сурах бичгийг үндсэн сурахаар ашиглаж байв.
7. Бүс нутаг судлал /Зүүн Хойд Ази судлал/ /сонгон/ - ОУУБИС “Солонгосын олон улсын харилцаа” хичээлээр Зүүн хойд азийн бүс нутгийн төлөв байдлын талаар Ж.Баттөр “Зүүн хойд азийн бүс нутгийн төлөв, Монгол судлалын харилцаа”, ОУУБИС-аас хэвлэсэн “Монгол Солонгосын харилцааны түүх ба Зүүн хойд азийн хамтын ажиллагаа” сурах бичиг болон нэмэлтээр олон улсын харилцаа, Монгол улс БНАСАУ-ын харилцааны тухай ном, материал ашиглаж байна.
8. Солонгосын уран зохиол – 2000 оноос хойш солонгосын уран зохиолыг монгол уншигчид, солонгос хэл, орон судлаачдад танилцуулах зорилготой шүлэг, өгүүлэл, тууж, роман тодорхой тоогоор орчуулагдан гарсан нь энэ хичээлийг зааж буй багш нар хичээлийн материалаар ашиглах өргөн боломж нээгдсэн. МУИС-д Солонгосын уран зохиолтой холбоотой гурван төрлийн хичээл төлөвлөгдсөнөөс Солонгосын уран зохиолын удиртгал хичээл заавал судлах хэлбэрээр, бусад хоёр хичээл буюу Солонгосын орчин үеийн уран зохиол, сонгодог уран зохиол хичээлүүд сонгон хэлбэрээр судлагдахаар хөтөлбөрт тусгагджээ. Солонгосын уран зохиолын удиртгал хичээлд И Соньни, Ким Хёнъян, Чэ Хусог “Гадаад хүнд зориулсан солонгосын уран зохиолын түүх” сурах бичгийг үндсэн сурах бичгээр, Ким Гёнбуг, Мён Хёндэй, Бён Жунхён, И Вонсү “Солонгосын уран зохиолын тухай ойлголт” болон монгол судлаачдын орчуулсан Солонгосын уран зохиолын бүтээлүүдтэй танилцахаар тусгасан. “Солонгосын сонгодог уран зохиолын дээжис” хичээлээр Тон-а их сургуулиас эрхлэн хэвлүүлсэн “Корйё улсын судар”, Ким Бүшиг, Гурван улсын Түүхэн тэмдэглэл, Гурван улсын нөхсөн судар зэрэг сурвалж бичгүүдийг ашигладаг гэжээ. ОУУБИС-д заавал судлахаар Солонгосын орчин үеийн уран зохиол, сонгон судлахаар Солонгосын эртний уран зохиол гэсэн хоёр хичээлийг судалдаг бөгөөд Ин Танми “Солонгосын орчин цагийн уран зохиол 1, 2” сурах бичгийг үндсэн сурах бичгээр, монгол хэл дээр орчуулагдсан солонгосын уран зохиолуудыг нэмэлт материал хэлбэрээр ашиглаж байна. Энэ хичээл прагматик талыг голлон анхаарсан нь ажиглагдаж байна.
9. Солонгосын угсаатны зүй – ОУУБИС Т.Буяннэмэх “Солонгосын угсаатан судлал сурах бичгийг үндсэн сурах бичгээр, Д.Сайнбилэгт “Солонгосын улс төр”,

Г.Эрдэнэчимэг “БНСУ-ын эдийн засгийн тойм”, Г.Эрдэнэчимэг “Солонгосын түүх 1,2”, Чуэй Үншиг “Солонгосын угсаатны зүй судлалын удиртгал” сурах бичгийг нэмэлт материалаар ашиглаж байна.

10. Эртний солонгос хэл - И Гимүнь “Төрөлх хэлний түүх удиртгал”, И Гимүнь “Төрөлх хэлний авиа зүйн судалгаа”, Квон Жэиль “Солонгос хэлний хэлзүйн түүх” болон орчуулсан Д.Сайнбилэгтийн орчуулсан Иргэнийг сургах зөв аялгуу, Ирйөнъ Гурван улсын нөхсөн судар, орчуулсан Ц.Цэрэндорж, Ким Бүшиг, Гурван улсын түүхэн тэмдэглэл, орчуулсан Ц.Цэрэндорж зэрэг эх сурвалж дээр ажиллахаар тусгажээ.
11. Монгол Солонгосын харилцааны түүх – Ц.Цэрэндорж “14-р зууны сүүл хагасын Зүүн азийн олон улсын дэг журам ба Хойд Юань улс, Гуулин улсын харилцаа” докторын нэг сэдэвт бүтээлийг үндсэн сурах бичгийн үүргээр, нэмэлт материалаар Ирйөнъ “Гурван улсын нөхсөн судар”, “Монгол-Солонгосын харилцаа: түүх ба баримт (1945-1990) болон судалгааны ном, өгүүлэл ашиглаж байна.

Дүгнэлт

1990-ээд оноос хойш Монголд солонгос хэл эрчимтэй зааж эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд солонгос хэлний сурах бичиг зохиох ажил Солонгос талын дэмжлэгтэйгээр тодорхой хэмжээнд ахиц дэвшил гарсан гэж үнэлж болох юм. Гэвч 3, 4 дүгээр курст судлах мэргэшүүлэх хичээл болох нийгэм-эдийн засаг, уран зохиол-урлаг, угсаатны зүй, түүх улс төр зэрэг хичээлийн сурах бичиг дутагдалтай, эсвэл тогтсон сурах бичиггүйн улмаас хичээлийн агуулгад тохируулан материал эмхэтгэн ашиглах, шаардлагатай үед агуулгад тааруулан материал бэлдэх зэргээр явж ирсэн³ хэмээн судлаач Квон Сонхүнь 2009 онд онцолж байсан нь мэргэшүүлэх хичээл төдийгүй мэргэжлийн заавал судлах хичээлүүдийн хувьд одоо ч тодорхой өөрчлөлт гарсан харагдахгүй байна. Монгол орон судлаачид, эрдэмтэн, багш нарын зохиож, эмхэтгэсэн сурах бичиг бүхий хичээлийн хувьд тухайн хичээл заавал судлах, сонгон судлах хичээлээс үл хамааран үндсэн сурах бичгээр ашиглаж байгаа нь ажиглагдлаа. Иймд сурах бичиг, гарын авилаггүй солонгос судлалын хичээлд ашиглах сурах бичиг зохиох шаардлага байгаа нь тодорхой харагдаж буй бөгөөд сурах бичиг зохиохгүй байгаа шалтгааныг солонгос судлаачид, багш, ер солонгос хэлний мэргэжилтнүүдээс асуумж авч тодорхойлох шаардлагатай. Энд мэргэжлийн ур чадвар дутагдалтай гэхээс илүүтэй гадаад, дотоодын санхүүгийн дэмжлэгтэй холбоотой болов уу

³ 권성훈, 『몽골에서의 한국어교육과 연구』, 한·몽 수교 10주년 기념 학술회의 자료, 몽골국립대학교, 2000, 93 쪽

Ашигласан материал

1. Д.Эрдэнэсүрэн, Их дээд сургуулиудын солонгос хэлний сурах бичгийн асуудалд, Ази судлал Олон улсын эрдэм шинжилгээний зургаадугаар хурал, 2020
2. 강신, 『몽골에서의 한국어교육의 현황과 과제』, 『몽골학』제 22 호, 한국몽골학회, 2007, 161 쪽
3. 권성훈, 『몽골에서의 한국어교육과 연구』, 한·몽 수교 10 주년 기념 학술회의 자료, 몽골국립대학교, 2000, 93 쪽
4. 권성훈, 『몽골 대학들의 한국어교육』, 『한국어문학연구』제 56 집, 한국어문학연구회, 2009, 83-87 쪽
5. 이안나, 『몽골에서의 한국어 교육의 과제』, 제 4 차 해외 한국어 교육자 워크숍, 국제한국어교육학회, 2005, 51-52 쪽
6. 아디아수렝, 몽골에서의 한국어 교재 현황과 개발 방안 -울란바타르대학교 교재를 심으로, 석사학위논문, 2008
7. 오르тна승, 몽골 한국어 교재의 문화 내용 분석과 개선 방안 연구 - 국제울란바타르 대학교 교재를 중심으로, 석사학위논문, 2021
8. 성비락, 『몽골인 학습자를 위한 한국어 문법 기반 교재의 내용 구성 방안』, 국제한국어교육학회 14 차 학술대회, 2004, 326 쪽
8. 조항록(2010), 『한국어 교육 현장의 주요 쟁점 -교재, 평가, 문화교육』, 한국문화사, 9-17 쪽
9. Norovnyam.B, 『몽골에서의 한국어교육 현황』, 제 4 차 해외 한국어 교육자 워크숍, 국제한국어교육학회, 2005, 39-40 쪽

외국어 교수법 발전 동향과 몽골인을 위한 한국어 교수법 개발

- “SODAR” 교수법 개발의 예를 중심으로 -

B.Ariunbaatar

국제울란바타르대학교, 한국어교육학과

2023.04.12

Гадаад хэл заах аргын хөгжлийн чиг хандлага ба Монгол дахь солонгос хэлний заах арга хөгжүүлэлт

- “Содар” аргын жишээ -


발표 내용

- ❖ 교육 활동과 교수법 (서론)
- ❖ 외국어 교수법 발전 동향
- ❖ Richard & Rodgers의 교수법
개발 모형
- ❖ “SODAR” 교수법 개발의 예

1. 교육활동과 교수법

교육 활동

- 교육과정
- 교육과정의 실행을 위한 교수법
- 교수법을 동원하는 교재(교과서)



교육과정

- 누가?
- 누구를 위해?
- 무엇을? - 내용 vs 방법
- 어떤 성과 (outcomes)?
- 누가 - 출판사, 대학교, 학교, 교사?
- 동일된 교육과정 - 교육과정 표준화

NOT
NOW

Top-down approach

교재

Course book is still **ubiquitous and plays a fundamental role** in language teaching around the world. It has become an almost **universal element** of language teaching (Tomlinson, 2014)

교과서 중심의 교육 활동 - Хэт сурах бичиг төвтэй

Many ELT materials currently make a significant contribution to the failure of many learners of English

Tomlinson, 2008




교과서 때문에 실패!

오늘의 교과서

- 발전과 습득을 위한 기회를 주는 것보다 언어적 요소에 초점을 둔다
- 대부분의 출판사와 교과서 개발자들이 주역을 한다 - **publishers and textbook writers**
- 교수자들이 교재를 만들 여유가 없다 - but they **feel sorry** for their students because it was **so boring**

오늘의 교재

- 12개 국가를 대상으로 한 조사 결과 교과서의 85% 정도는 행정인, 15% 정도는 교수자, 0%는 학생이 정해 주고 있다.
- 수업 준비를 위한 부담을 최소화하기 때문에 교사들이 미리 정해준 교과서 (a best-selling coursebook)를 선호한다.
- There is **no risk**



교과서는 어떤 문제가 있는가 ?

- ❖ 그 학습자들의 필요를 충족해 주지 못 한다 - **needs** of a particular group
- ❖ 현지의 특징을 고려하지 못하여 문화적으로 안 맞는다 - **culture and local context**
- ❖ 시대에 통떨어질 수 있다 - can be **outdated**.
- ❖ 활용성이 떨어질 수 있다 - not **authentic**.
- ❖ 교수자들의 **창의성**을 저하시킨다 - **teacher's creativity**.

“Every teacher is a materials developer”

모든 교수자들이 교재 개발자여야 한다.

2. 외국어 교수법 발전 동향

외국어 교수법의 발전사

- ❖ 문법번역식 교수법 Grammar translation method (1800-1900)
- ❖ 직접식 교수법 Direct method (1890-1930): like first language
- ❖ 청각 구두식 교수법 Audiolingual method (1950-1970): repeat
- ❖ 침묵식, 자연 교수법 The Silent Way, natural approach (1960 -)
소통 중심 교수법 Communicative approach (1970-): interaction



Methods 시대의 문제점

- 라틴어 - 영어 - 한국어
- 모든 교수자를 위한 교수법 - 교실 외부에서 개발
- 학습자 중심성과 교수자 창의성은 없다
- 교수자가 자신을 교수법 맞추어야 한다 - must submit to the method

The best teaching method

No!

Richard & Rodgers, 2001

methods typically prescribe for teachers what and how to teach. Teachers have to accept on faith the claims or theory underlying the method and apply them to their own practice. Good teaching is regarded as correct use of the method and its prescribed principles and techniques. Roles of teachers and learners, as well as the type of activities and teaching techniques to be used in the classroom, are generally prescribed. The role of the teacher is marginalized; his or her role is to understand the method and apply its principles correctly. Likewise, learners are sometimes viewed as the passive recipients of the method and must submit themselves to its regime of exercises and activities. Absent from the traditional

Richard & Rodgers 2001

The methods era is gone away

Richards & Rodgers, 2001

그런 교수법의 시대가 이미 지나
갔다

교수법의 최근 동향

세계적으로 통일된 교수법을 따르는 전통 - **one general method**



paradigm shift


학습자의 필요, 흥미, 학습 환경에 맞는 구체적 교수법을 교수자가 직접
만드는 시대 - **specific method**

**postmethod
era**

교수법의 최근 동향

Pedagogy/didactics의 역할?

일정 교수법을 강요하는 것이 아니라 교수자가 현장에 맞는 독창적인 교수법을 **개발할 수 있게** 도와주는 것



postmethod era

Postmethod 시대의 특징

3P

- **particularity** - 독특성
- **practicality** - 실용성
- **possibility** - 독창적이고 창의적 교수법 개발의 기회

Postmethod 시대의 특징

- 구체적인 방법이 아니라 방향성 - Macro strategies
- 구체적인 기술을 제공하지 않는다 - Not the technique of learning activity
- 자신만의 교수법과 모델을 만들도록 한다 - Own teaching method and models

Second
Language
teaching

Method era

교육이란 무엇인가를 가르치는 것
(about teaching people something) -
학습 내용 자체가 목적

Postmethod era

교육이란 학습자가 자신의 방법을 찾을
수 있는 방향성- developing a reliable
compass and **the navigation skills** to
find their own way

학습 이론의 최근 동향

우리는 어떻게 해야 되는가

more **up-to-date teaching methods** , **latest understanding** of the nature of language and of language learning


- 언어학 - 언어 구조와 원리에 대한 이해 - the organization and structure of language
- 심리학 - 학습 과정의 원리 - nature and procedure of learning
- 언어습득론 (SLA) - 언어 학습과 습득의 원리
- 교육학 이론 - 학습이론, 교육과정학, 외국어 교수법




3. Richard & Rodgers의 교수법 개발 모형

교수법의 개념 및 교실 활동

Richard & Rodgers 2001



Richards & Rodgers의 교수법 모형



Richard & Rodgers의 교수법 개발 모형

- ❖ **언어 학습에 대한 관점** - 언어 본질, 언어 학습과 언어습득 원리
- ❖ **교육 내용과 활동 디자인** - 교육의 목적, 내용, 교육 활동에 대한 계획과 교육과정
- ❖ **실행 절차** - 현장에서의 교육활동 실행


4. SODAR 교수법 개발



SODAR의 뜻


Солонгос хэлийг
содон аргаар

한국어를 독창적인 방법으로



SODAR

- ❖ 더 효율적인 방법 없을까?
- ❖ Practice로부터 시작 (이론 = 점검 도구)
- ❖ 교재 - 교수법 - 교육과정




SODAR와 Richards & Rodgers 모형 비교교

단계	SODAR 교수법	Richards & Rodgers 모형
1 단계	언어란 무엇인가? 언어의 본질과 습득 원리, 한국어의 특징	이념과 관점 - 언어의 본질과 언어 학습 원리
2 단계	어떤 내용을 포함해야 하는가? 내용 선정과 디자인	디자인 - 목적, 내용, 교육 활동 계획
3 단계	어떻게 가르칠 것인가? 교수학습 활동으로 실행	절차 (procedure) - 교수학습 활동에 대한 기술, 실제, 상호작용

언어란 무엇인가?

언어 = 의사소통의 도구
communication tools



언어 학습

언어 학습 = 언어 활용 방법 습득

- 발음, 소리를 바르게 내는 방법
- 어휘 습득과 사용 방법 - үг тогтоох (холбох), хэрэглэх арга
- 문장 구조 - 단어를 연결해서 문장 만드는 방법

사용 = 원리 + 방법

내용선정과 디자인

초급의 경우

- 발음: үсэг тогтоох; хэл хэвшүүлэх; зөв дуудаж, уншиж сурах
- 어휘: 초급 어휘 420 үг (명사 200; 동사 100; 형용사 60; 부사 60개)
- 문장: 문장 구조와 원리, 주요 조사 및 어미 각 20개씩
- 읽기, 듣기, 말하기 연습 = 언어 활용



실행

실행 원칙

- 쉽게
- 재미있게
- 독특하게 (독창적, 창의적인인)

Нийгмийн болон харилцааны үйлдэл 2



선생님은 가르치고 학생은 배우고, 가끔 때리고 싸우면 경찰을 부른다.




Principles and techniques

단계	기본 원칙	실행 방식/기술
관점과 이념 확정	방법을 찾으면 쉽다 (언어 본질과 습득 원리)	원리를 이해시키고 방법을 배울 수 있게 방법을 찾도록 하여 배울 수 있다는 믿음을 주기
내용 선정과 디자인	적합 내용을 정확하게 내용이 아니라 원리와 방법 을	발음: 한글, 받침, 발음 동화 등 어휘: 꼭 알아야 하는 기초 어휘 습득과 활용 문장: 문장 구조에 대한 이해, 기본 조사와 어미 활용
실행	쉽게, 재미있게, 독특하게	Үсэг нүдэлж, хэл хэвшүүлэх (한글 + 발음) Үг тогтоож, холбож сургах (어휘 습득, 활용) 읽기, 듣기, 말하기 등으로 언어 능력을 활용할 수 있도록 도와 주기

결론


- ❖ 외국어 교수법의 세계적인 동향은 하나의 통일된 교수법으로부터 교수자마다의 독창적인 교수법으로 - postmethod era로
- ❖ 따라서 오늘날 모든 교수자가 교수법 개발자여야 한다
- ❖ SODAR 교수법 개발은 개발은 위와 같은 세계적 동향과 Richards & Rodgers의 이론적인 모델과 맞대고 있다

가르치려고 하는 것의 본질과 원리를 올바르게 이해하고,
학습할 내용을 잘 디자인하여, 실행 방법과 방식을 확정해서
창의적으로 실행해 나아가면 학습은 쉽고, 재미있고,
효율적일 것이다.



**방법을 알면
쉽죠**

Багш заах гэж байгаа зүйлийнхээ **мөн чанар, зүй тогтлыг зөв ойлгож**, заах агуулгаа **бүтээлчээр, оновчтой дизайнчлан**, хэрэгжүүлэх **арга замуудыг тодорхой болгож бүтээлчээр хэрэгжүүлсэн** тохиолдолд л хичээл **хялбар, сонирхолтой, үр өгөөжтэй** байна.



**Аргыг нь
олбол амархан**

참고 문헌

- Garton, S., & Graves, K. (2014). International perspectives on materials in ELT. Springer.
- Kumaravadivelu, B. (2006). Understanding language teaching: From method to postmethod. Routledge.
- Richards, J. C., & Rodgers, T. S. (2001). Approaches and methods in language teaching. Cambridge university press.
- Richards, J. C., & Rodgers, T. S. (2014). Approaches and methods in language teaching. Cambridge university press.
- Tomlinson, B. (2017). Achieving a match between SLA theory and materials development. *SLA research and materials development for language learning*, 1-22.